



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЮНЕСКО-ИЙН МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ КОМИССЫН 2021 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН  
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/120/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх  
аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Д.Энхдалай  
Утас: 261885 Цахим хаяг: [enkhdalaid@audit.gov.mn](mailto:enkhdalaid@audit.gov.mn)  
Аудитор: С.Отгонхорлоо  
Утас: 261740 Цахим хаяг: [otgonkhorloos@audit.gov.mn](mailto:otgonkhorloos@audit.gov.mn)  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Азуре Хүлүг Аудит ХХК  
Захирал: Г.Мөнхбаяр  
Утас: 70110090 Цахим хаяг: [audit@azure.mn](mailto:audit@azure.mn)

Улаанбаатар хот  
2022 он

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Төлбөрийн акт	16
4.2 Албан шаардлага	16
4.3 Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ЮНЕСКО-ИЙН МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ  
КОМИССЫН ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА С.БОЛДСАЙХАН  
ТАНАА

2022.02.24 № 07/312  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

**ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

ДАНС	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>79,802,310.19</b>	<b>312,555,116.87</b>
<b>31</b>	<b>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</b>	<b>272,704.31</b>	<b>-</b>
311	Кассад байгаа бэлэн мөнгө	272,704.31	-
31130	Нэмэлт санхүүжилт	272,704.31	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>55,466,087.18</b>	<b>163,942,904.17</b>
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	7,822.28	-
33300	Татаас санхүүжилтийн авлага	54,573,922.63	163,686,338.28
335	Бусад авлага	884,342.27	256,565.89
3351	Байгууллагаас авах авлага	301,413.15	256,565.89
3352	Хувь хүмүүсээс авах авлага	582,929.12	-
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>-</b>	<b>124,253,978.00</b>
34600	Урьдчилж гарсан зардал	-	124,253,978.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>24,063,518.70</b>	<b>24,358,234.70</b>
354	Хангамжийн материал	24,063,518.70	24,358,234.70
35410	Бичиг хэргийн материал	1,224,300.00	754,600.00
35440	Түлш шатах тослох материал	1,621,127.03	931,259.03
35470	Бусад хангамжийн материал	21,218,091.67	22,672,375.67
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>148,458,174.87</b>	<b>11,093,720.37</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>148,458,174.87</b>	<b>11,093,720.37</b>
392	Биет хөрөнгө	148,458,174.87	10,832,470.36
39203	Авто тээврийн хэрэгсэл	55,000,000.00	55,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(55,000,000.00)	(55,000,000.00)
39205	Машин, тоног төхөөрөмж	68,367,004.00	22,760,430.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(22,740,131.85)	(14,842,147.44)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	89,575,147.00	19,575,147.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(27,960,555.28)	(19,292,180.20)
39214	Бусад үндсэн хөрөнгө	56,252,541.00	4,862,421.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(15,303,330.00)	(2,498,700.00)
39217	Номын фонд	267,500.00	267,500.00
393	Биет бус хөрөнгө	-	261,250.01
39301	Программ хангамж	770,000.00	1,045,000.00
39302	Хасагдуулаг	(770,000.00)	(783,749.99)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>228,260,485.06</b>	<b>323,648,837.24</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>55,018,658.97</b>	<b>164,821,218.34</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>55,018,658.97</b>	<b>164,821,218.34</b>
413	Өглөг	55,018,658.97	164,821,218.34
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	154,488.23	1,025,231.97
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-
4136	Бусад өглөг	54,864,170.74	163,795,986.37
41361	Байгууллагад төлөх өглөг	54,573,922.63	163,686,338.28
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	290,248.11	109,648.09
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>173,241,826.09</b>	<b>158,827,618.90</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	173,241,826.09	158,827,618.90
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	78,398,015.00	78,398,015.00
51101	Өмч: -Төрийн өмч	78,398,015.00	78,398,015.00
512	Хуримтлагдсан үр дүн	94,843,811.09	80,429,603.90
51210	Өмнөх үеийн үр дүн	94,843,811.09	94,843,811.09
51220	Тайлант үеийн үр дүн	-	(14,414,207.19)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>228,260,485.06</b>	<b>323,648,837.24</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он /Төгрөгөөр/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>600,280,709.90</b>	<b>786,139,188.18</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>423,953,709.90</b>	<b>612,434,488.18</b>
120	Нийтлэг татварын бус орлого	423,953,709.90	612,434,488.18
120009	Бусад орлого	423,953,709.90	612,434,488.18
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>176,327,000.00</b>	<b>173,704,700.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	176,327,000.00	173,704,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	176,327,000.00	173,704,700.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>750,248,438.27</b>	<b>800,553,395.37</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>750,248,438.27</b>	<b>800,553,395.37</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>727,798,572.55</b>	<b>784,134,387.81</b>
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	106,200,447.88	104,982,443.77
210101	Цалин	81,029,750.02	87,150,214.72
210102	Нэмэгдэл цалин	14,508,764.77	8,478,248.09
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,661,933.09	9,353,980.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,788,105.71	12,217,938.45
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	4,145,273.61	9,216,894.24
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	235,050.35	549,593.61
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	293,812.92	432,954.92
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	58,762.59	104,640.34
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	1,055,206.24	1,913,855.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,575,418.36	11,684,921.67
210304	Байрны түрээс	10,575,418.36	11,684,921.67
2104	Хангамж, бараа материалын зардал	7,338,044.00	6,392,598.60
210401	Бичиг хэргийн материал	2,083,336.00	2,503,704.31
210402	Тээвэр, шатахууны зардал	2,091,508.00	2,743,978.00
210403	Шуудан холбоо интернэтийн төлбөр	3,163,200.00	1,144,916.29
2105	Нормативт зардал	18,884,646.00	23,625,558.00
210502	Хоол	18,884,646.00	23,625,558.00
2107	Томиллолт, зочны зардал	409,199.86	-
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	409,199.86	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	294,729,154.82	378,363,188.07
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	292,192,654.82	374,948,791.07
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	2,100,000.00	3,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	198,000.00	175,897.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	194,500.00	194,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	283,873,555.92	246,867,739.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	248,427,894.50	215,805,143.89
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	35,445,661.42	31,062,595.36
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>22,449,865.72</b>	<b>16,419,007.56</b>
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,449,865.72	16,419,007.56
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,449,865.72	16,419,007.56
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)</b>	<b>(149,967,728.37)</b>	<b>(14,414,207.19)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)</b>	<b>(149,967,728.37)</b>	<b>(14,414,207.19)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он /Төгрөгөөр/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>654,854,632.53</b>	<b>949,825,526.46</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>654,854,632.53</b>	<b>949,825,526.46</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	176,327,000.00	173,704,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	176,327,000.00	173,704,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	478,527,632.53	776,120,826.46
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	444,211,089.93	776,120,826.46
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	34,316,542.60	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>656,787,928.22</b>	<b>949,823,230.77</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	656,787,928.22	949,823,230.77
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	579,764,139.87	769,717,884.93
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	106,397,921.73	104,982,443.77
210101	Үндсэн цалин	81,227,223.87	85,935,656.11
210102	Нэмэгдэл	14,508,764.77	7,883,795.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,661,933.09	11,162,992.07
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,788,105.71	12,217,938.45
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	4,145,273.61	9,216,894.24
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	235,050.35	549,593.61
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	293,812.92	432,954.92
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	58,762.59	104,640.34
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	1,055,206.24	1,913,855.34
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	10,575,418.36	11,684,921.67
210304	Байрны түрээс	10,575,418.36	11,684,921.67
2104	Хангамж, бараа материалын зардал	9,348,120.00	7,475,522.58
210401	Бичиг хэрэг	3,020,920.00	4,099,090.00
210402	Тээвэр, шатахуун	3,164,000.00	2,099,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,163,200.00	1,276,832.58
2105	Нормативт зардал	18,688,700.00	23,625,558.00
210502	Хоол, хүнс	18,688,700.00	23,625,558.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,943,440.00	-
210601	Багаж техник хэрэгсэл	10,943,440.00	-
2107	Томилолт, зочны зардал	409,199.86	-
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	409,199.86	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	309,323,004.64	499,685,190.07
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	306,786,504.64	496,270,793.07
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,100,000.00	3,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	198,000.00	175,897.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	194,500.00	194,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	108,290,229.57	110,046,310.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	108,290,229.57	110,046,310.39
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>77,023,788.35</b>	<b>180,105,345.84</b>
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	77,023,788.35	180,105,345.84
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	77,023,788.35	16,419,007.56
213305	Хөрөнгийн	-	163,686,338.28
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>(1,933,295.69)</b>	<b>2,295.69</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	<b>275,000.00</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	275,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	275,000.00

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	275,000.00
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(1,933,295.69)</b>	<b>272,704.31</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>2,206,000.00</b>	<b>272,704.31</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>272,704.31</b>	<b>-</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>78,398,015.00</b>	<b>244,811,539.46</b>	<b>323,209,554.46</b>
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>78,398,015.00</b>	<b>244,811,539.46</b>	<b>323,209,554.46</b>
Тайлант үеийн үр дүн	-	(149,967,728.37)	(149,967,728.37)
<b>2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>78,398,015.00</b>	<b>94,843,811.09</b>	<b>173,241,826.09</b>
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>78,398,015.00</b>	<b>94,843,811.09</b>	<b>173,241,826.09</b>
Тайлант үеийн үр дүн	-	(14,414,207.19)	(14,414,207.19)
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>78,398,015.00</b>	<b>80,429,603.90</b>	<b>158,827,618.90</b>



## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
			Зөрүү	Хувь
<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>173,704,700.00</b>	<b>157,285,692.44</b>	<b>16,419,007.56</b>	<b>90.6</b>
<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>173,704,700.00</b>	<b>157,285,692.44</b>	<b>16,419,007.56</b>	<b>90.6</b>
Бараа, үйлчилгээний зардал	173,704,700.00	157,285,692.44	16,419,007.56	90.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	115,278,800.00	104,982,443.77	10,296,356.23	91.1
Үндсэн цалин	92,661,900.00	85,935,656.11	6,726,243.89	92.7
Нэмэгдэл	10,960,200.00	7,883,795.59	3,076,404.41	71.9
Унаа, болон бусад нөхөн олговор	11,656,700.00	11,162,992.07	493,707.93	95.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,562,700.00	12,217,938.45	3,344,761.55	78.5
Тэтгэврийн даатгал	10,951,500.00	9,216,894.24	1,734,605.76	84.1
Тэтгэмжийн даатгал	1,152,800.00	549,593.61	603,206.39	47.7
ҮОМШӨ ний даатгал	922,200.00	432,954.92	489,245.08	46.9
Ажилгүйдлийн даатгал	230,600.00	104,640.34	125,959.66	45.4
Эрүүл мэндийн даатгал	2,305,600.00	1,913,855.34	391,744.66	83.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,778,100.00	11,684,921.67	93,178.33	99.2
Байрны түрээс	11,778,100.00	11,684,921.67	93,178.33	99.2
Хангамж, бараа материалын зардал	4,350,800.00	4,163,832.58	186,967.42	95.7
Бичиг хэрэг	787,600.00	787,400.00	200.00	99.9
Тээвэр (шатахуун)	2,381,800.00	2,099,600.00	282,200.00	88.2
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	1,181,400.00	1,276,832.58	(95,432.58)	108.1
Томиллолт, зочны зардал	571,400.00	-	571,400.00	-
Дотоод албан томиллолт	187,400.00	-	187,400.00	-
Зочин төлөөлөгч хүлээн авах	384,000.00	-	384,000.00	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	23,008,200.00	21,683,697.22	1,324,502.78	94.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,571,700.00	18,269,300.22	1,302,399.78	93.4
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	198,000.00	175,897.00	22,103.00	88.8
Тээврийн хэрэгслийн татвар	194,500.00	194,500.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	3,154,700.00	2,552,858.75	601,841.25	80.9
Бараа үйлчилгээний бусад зардал	3,154,700.00	2,552,858.75	601,841.25	80.9
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>173,704,700.00</b>	<b>157,285,692.44</b>	<b>(16,419,007.56)</b>	<b>-</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>173,704,700.00</b>	<b>157,285,692.44</b>	<b>(16,419,007.56)</b>	<b>-</b>
<b>Улсын төсвөөс санхүүжих</b>	<b>173,704,700.00</b>	<b>157,285,692.44</b>	<b>(16,419,007.56)</b>	<b>-</b>
АЖИЛЛАГСДЫН ТОО	9	9	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	5	5	-	100.0
Үйлчлэх ажилтан	3	3	-	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл /төгрөгөөр/
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	272,704.31
<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>612,707,192.49</b>
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	612,707,192.49
Бараа, үйлчилгээний зардал	-	612,707,192.49
Хангамж, бараа материалын зардал	-	3,311,690.00
Бичиг хэрэг	-	3,311,690.00
Нормативт зардал	-	23,625,558.00
Хоол, хүнс	-	23,625,558.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	478,001,492.85
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	478,001,492.85
Бараа үйлчилгээний бусад зардал	-	107,768,451.64
Бараа үйлчилгээний бусад зардал	-	107,768,451.64
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>612,434,488.18</b>
БУСАД ЭХ ҮҮСВЭР	-	612,434,488.18
Бусад орлого	-	612,434,488.18
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	<b>272,704.31</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комиссын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримт бүрдүүлэлт, авлага, өглөөтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 21-ны хооронд Азуре хүлэг аудит ХХК-ийн аудитор Ч.Насанбат, аудиторын туслах П.Болортуяа нар гүйцэтгэж, хяналтыг гүйцэтгэх захирал Г.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн МҮК/22/31 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллага нь Монгол улс, ЮНЕСКО-ийн үзэл санаа, уриа дуудлагыг түгээн дэлгэрүүлэх, хэрэгжүүлэхэд үндэсний байгууллагуудыг өргөнөөр оролцуулах, ЮНЕСКО-Монголын хамтын ажиллагааг төлөвлөн чиглүүлэх, уялдуулан зохицуулах үүргийг гүйцэтгэх зорилготой байна.

ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Үйл ажиллагаанд Монгол улсын эрх ашгийг эрхэмлэн улс орны эдийн засаг, нийгмийн салбарт тавигдаж байгаа зорилтыг хэрэгжүүлэхэд нэмэр хандив оруулахыг чармайна.
- Юнеско-ийн үйл ажиллагаанд Монгол улсын идэвхтэй оролцоог хангаж боловсрол, шинжлэх ухаан, соёл, мэдээллийн салбарт түүний бүсийн төвүүд, үндэсний байгууллагатай хамтын ажиллагааг зохицуулна.
- Монгол орны түүх соёлын өв, дурсгалт зүйл, байгалийн өвөрмөц тогтоц, үнэт ховор баялаг, нөөцийг хайрлан арвижуулах, нөхөн сэргээх талаар ЮНЕСКО, түүний гишүүн орнуудтай нягт хамтран ажиллах чиглэлийг удирдлага болгоно.
- Дэлхий нийтийн боловсрол, шинжлэх ухаан, соёл, мэдээллийг хөгжүүлэхэд чиглэсэн бүхий үйл ажиллагааг идэвхтэй дэмжин улс түмний ойлголцол итгэлцлийг нэмэгдүүлэхэд тус төхөм үзүүлнэ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль Монгол Улсын Их Хурлаар 2021 оны 6 дугаар сарын 11-нд батлагдаж, 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэн;

- Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол;
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Гадаад харилцааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2021 онд ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 3 дугаар улирлын нийт зардлын 440,433.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,404.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 буюу 3,303.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 95,388.4 мянган төгрөгөөр буюу 42 хувиар өссөн

байна. Өмнөх оны үзүүлэлтээс татаас санхүүжилтийн авлага, урьдчилж гарсан зардал, үндсэн хөрөнгийн данснууд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	272.7	-	(272.7)
Татаас санхүүжилтийн авлага	55,466.1	163,942.9	108,476.8
Урьдчилж гарсан зардал	-	124,254.0	124,254.0
Бараа материал	24,063.5	24,358.2	294.7
Үндсэн хөрөнгө	148,458.2	11,093.7	(137,364.5)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>228,260.5</b>	<b>323,648.8</b>	<b>95,388.4</b>
Богино хугацаат өр төлбөр	55,018.7	164,821.2	109,802.6
Цэвэр хөрөнгийн дүн	173,241.8	158,827.6	(14,414.2)
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгийн дүн</b>	<b>228,260.5</b>	<b>323,648.8</b>	<b>95,388.4</b>

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Нэмэлт санхүүжилтийн харилцах дансны 163,942.9 мянган төгрөгийн үлдэгдлийг Сангийн яамнаас татан төвлөрүүлсэн бөгөөд тооцоо нийлж татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн.
- Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 124,254.0 мянган төгрөг нь он дамжин хэрэгжих оролцооны хөтөлбөрийн төлбөрүүд юм.
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 137,364.4 мянган төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 10 сарын 19-ний өдрийн 434 тоот албан бичгийн дагуу 166,996.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг Соёлын өвийн үндэсний төв рүү шилжүүлэн өгсөн, тайлант оны элэгдлийн зардалд 31,026.6 мянган төгрөгийн тооцоолж бүртгэсэн зэргээс тус тус шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>Үйл ажиллагааны орлогын дүн</b>	<b>600,280.7</b>	<b>786,139.2</b>	<b>185,858.5</b>
Бусад орлого	423,953.7	612,434.5	188,480.8
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	176,327.0	173,704.7	(2,622.3)
<b>Үйл ажиллагааны зардлын дүн</b>	<b>750,248.4</b>	<b>800,553.4</b>	<b>50,305.0</b>
Бараа, ажил үйлчилгээний зардал	727,798.6	784,134.4	56,335.8
Урсгал шилжүүлэг	22,449.9	16,419.0	(6,030.9)
<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>(149,967.7)</b>	<b>(14,414.2)</b>	<b>135,553.5</b>

Тус байгууллагын үйл ажиллагааны нийт орлого өмнөх оноос 185,858.5 мянган төгрөгөөр буюу 30.9 хувиар өссөн байна. Тайлант онд улсын төсвөөс 173,704.7 мянган төгрөгийн санхүүжилт авсан нь өмнөх оноос 2,622.3 мянган төгрөгөөр буурсан бол нэмэлт санхүүжилтийн орлогоор 612,434.5 мянган төгрөгийн санхүүжилт авсан нь өмнөх оноос 188,480.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 50,305.0 мянган төгрөгөөр буюу 6.7 хувиар өссөн нь бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс 82,756.1 мянган төгрөгөөр өссөн, бараа ажил үйлчилгээний зардал 32,622.7 мянган төгрөгөөр буурсан зэргээс тус тус шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 273,778.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 203,907.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 98,912.7 мянган төгрөгөөр бууруулж 175,866.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор улсын төсвийн санхүүжилтийн эх үүсвэрийг 173,704.0 мянган төгрөг болгож баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 173,704.0 мянган төгрөгийн төсөв батлуулснаас гүйцэтгэлээр 157,285.7 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 16,419.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 157,285.7 мянган төгрөг буюу 90.5 хувьтай байгаа цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 10,296.4 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 3,344.7 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлсийг 1,302.4 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
	Код	Нэр				
1	70303	Олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх	173,704.7	157,285.7	16,419.7	91.1
2	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	173,704.7	157,285.7	16,419.7	91.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс нь 2021 онд ЮНЕСКО-ийн Бээжин дэх төлөөлөгчийн газар, ЮНЕСКО-гийн Парис дахь төв зэрэг байгууллагуудтай хийсэн гэрээний дагуу 776,120.8 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийг хүлээн авсан байна.

Тайлант онд 612,434.5 мянган төгрөгийг зарцуулж, 163,686.3 мянган төгрөгийг Сангийн яамны төрийн санд төвлөрүүлж, авлага үүсгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын үйл ажиллагаа нь дотоод ажил зохион байгуулалт, комиссын чадавхыг бэхжүүлэх, Ази, Номхон далайн орнуудад дээд боловсролын сургалт, эрдмийн зэрэг, дипломыг хүлээн зөвшөөрөх тухай бүсийн конвенцын Монгол улс дахь хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, ЮНЕСКО-ийн спортод сэргээш хэрэглэхийн эсрэг олон улсын конвенцын Монгол ус дахь 2020-2021 оны хэрэгжилтийн тайланг ЮНЕСКО-д хүргүүлэх ажлыг зохион байгуулах, Монгол улсын нэгдэж орсон ЮНЕСКО-ийн соёлын конвенцуудын хэрэгжилтийн хүрээнд хугацаат тайлангуудыг ЮНЕСКО-д хүргүүлэх гэсэн 4 бүрэлдэхүүн хэсгээс бүрддэг.

Тайлант онд төслийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөр, 1 арга хэмжээний хэрэгжилт 96.1 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 91.1 хувийн биелэлттэй, 5.0 хувийн зөрүүтэй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитын явцад шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Завсрын аудитаар нийт 98,325.3 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илрүүлснээс 8,944.4 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 89,380.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 88,991.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөд дахин үнэлгээг хийж 2022 оны 2 сарын 1-ний өдрийн МҮК/22/51 тоот албан бичгээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авахаар хүргүүлсэн байдалтай байна.

Өмнөх аудитаар шилэн дансны цахим хуудсанд 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчилд өгсөн 1 албан шаардлага болон алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар өгсөн 590.7 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	1	-	1	-	-	-	100.0
Зөвлөмж	3	590.7	3	590.7	-	-	100.0
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>590.7</b>	<b>4</b>	<b>590.7</b>	-	-	<b>100.0</b>

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Жендерийн талаарх ойлголтыг театраар дамжуулан техник, мэргэжлийн сургуулиудад олгох, залуус эх дэлхийнхээ төлөө болон Хүннүгийн эзэнт гүрний археологийн дурсгалуудын судалгаа, хадгалалт хамгаалалт, сурталчилгааны оролцооны төслүүдэд олгосон 124,253.9 мянган төгрөгийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хянаж үнэлэх, хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 88,991.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бүртгэл зэрэг асуудлыг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай.



#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,547.8 мянган төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрснээс, 386.7 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,134.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж, 1,026,3 мянган төгрөгийн алдаа, зөрчлийн цаашид давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 5 алдаа, зөрчлийн дүн 2,547.8 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал түвшин 4,404.3 мянган төгрөгөөс хэтрээгүй тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

##### 4.1 Төлбөрийн акт

1. ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс 386.7 төгрөгийн урамшууллыг ерөнхий нарийн бичгийн даргад олгохдоо холбогдох дээд шатны төсөв захирагчийн шийдвэрийг үндэслээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 1.2-т "Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно", 1.2.1-д "төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн шууд захирагчид шийдвэргүйгээр олгосон урамшууллыг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

##### 4.2 Албан шаардлага

1. Татварын өр төлбөрийг хуульд заасан хугацаанд бүрэн төлөөгүй, хувь хүний орлогын албан татварыг ажилтнаас илүү суутгаж 1,134.8 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлээгүй эрх ба үүрэг, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Татварын өр төлбөрийг хуульд заасан хугацаанд төлж, авлага өглөгийн тооцоо үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

##### 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

###### 1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Төрийн сангийн харилцах дансны зарлагын ажил гүйлгээнд 689.3 мянган төгрөгийн дүн бүхий 6 ажил гүйлгээ нь баримтын дүн зөрүүтэй, иж бүрдэл дутуу байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг хэрэгжүүлээгүй, иж бүрэн, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Мөнгөн зарлагын ажил гүйлгээний анхан шатны баримтын иж бүрдлийг хангаж ажиллах,

###### 2. Дансны авлагатай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Утасны төлбөр болон бичиг хэргийн материалын төлбөрийг нэхэмжлэхийн дүнгээс 319.4 мянган төгрөгөөр илүү шилжүүлэн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Төлбөр тооцоог анхан шатны баримт, нэхэмжлэхийн дагуу зөв хийж, авлага өглөгийн тооцоо үүсгэхгүй байх,

### **3. Бараа материалтай холбоотой асуудал**

3.1. Илрүүлэлт: Бараа материалын орлого, зарлагын ажил гүйлгээг анхан шатны баримт, гэрээтэй тулган шалгахад шаардах хуудсаар олгосон 17.6 мянган төгрөгийн бараа материалыг бүртгэлд тусгаж, зарцуулалтыг тайлагнаагүй байна.

Энэ нь ерөнхий нягтлан бодогч нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” үүрэгтэй гэж заасныг хэрэгжүүлээгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж: Бараа материалын зарцуулалтыг анхан шатны баримтыг үндэслэн цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25 № 15/А 015 0053

Улаанбаатар хот

АХР-2022/100/НА-СТА-ТЦЗ  
Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заалтын дагуу ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс 386,707.20 төгрөгийн урамшууллыг ерөнхий нарийн бичгийн даргад олгохдоо холбогдох дээд шатны төсөв захирагчийн шийдвэрийг үндэслээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 1.2 "Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно", 1.2.1 "төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3 заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс, илүү олгосон урамшуулал, 386,707.20 /Гурван зуун наян зургаан мянга долоон зуун долоон/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банканд дахь Аудитын шалгалтын орлогын 10090000601 тоот дансанд төвлөрүүлэх,
2. Актын биелэлтийг 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын ерөнхий нарийн бичгийн дарга С.Болдсайхан, нягтлан бодогч Л.Буянхишиг нарт хариуцуулав.

**АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
Г.МӨНХБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

9006109 110.10.10.20/Brohig\_Khereg/Akt/2022/0225 Auditin 2 Gasar-7.Docx  
9019120.596

001090035



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 53/А 015 0053

Улаанбаатар хот

АХГ-2022/190/НА-СТА-ТШЗ  
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заалтын дагуу ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын 2021 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Татварын өр төлбөр болох 1,025,231.97 төгрөгийг хуульд заасан хугацаанд бүрэн төлөөгүй, 109,648.09 төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг ажилтнаас илүү суутгаж өглөг үүсгэсэн байна.

Энэ нь нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Татварын өр төлбөрийг барагдуулж, зөрчлийг арилган биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын ерөнхий нарийн бичгийн дарга С.Болдсайхан, нягтлан бодогч Л.Буянхишиг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ЭНХДАЛАЙ

АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

МӨНХБАЯР

9006109  
9019120596

**ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс										
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох			Зөвлөмж	
							тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																	
1	ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс	АХГ-2022/120/НА-СТА-ТШЗ	ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс 386.7 төгрөгийн урамшууллыг ерөнхий нарийн бичгийн даргад олгоходоо холбогдох дээд шатны төсөв захирагчийн шийдвэрийг үндэслээгүй байна.	Төлбөрийн акт тогтоох	1	386.7			1	386.7							
2	ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс	АХГ-2022/120/НА-СТА-ТШЗ	Татварын өр төлбөрийг барагдуулаагүй, хувь хүний орлогын албан татварыг ажилтнаас илүү суутгаж өглөг үүсгэсэн байна.	Албан шаардлага хүргүүлэх	1	1,134.9					1	1,134.9					
3	ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс	АХГ-2022/120/НА-СТА-ТШЗ	Төрийн сангийн харилцах дансны зарлагын ажил гүйлгээнд 6 ажил гүйлгээ нь баримтын дүн зөрүүтэй, иж бүрдэл дутуу байна.	Зөвлөмж өгөх	1	689.3									1	689.3	
4	ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс	АХГ-2022/120/НА-СТА-ТШЗ	Утасны төлбөр болон бичиг хэргийн материалын төлбөрийг нэхэмжлэхийн дүнгээс 319.4 мянган төгрөгөөр илүү шилжүүлэн авлага үүсгэсэн байна.	Зөвлөмж өгөх	1	319.4									1	319.4	
5	ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс	АХГ-2022/120/НА-СТА-ТШЗ	Бараа материалын орлого, зарлагын ажил гүйлгээг анхан шатны баримт, гэрээтэй тулган шалгахад шаардах хуудсаар олгосон 17.6 мянган төгрөгийн бараа материалыг бүртгэлд тусгаж, зарцуулалтыг тайлагнаагүй байна.	Зөвлөмж өгөх	1	17.6									1	17.6	
<b>Дүн</b>					<b>5</b>	<b>2,547.9</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>386.7</b>	<b>1</b>	<b>1,134.9</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>1,026.3</b>